



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 192


Улаанбаатар хот

“ЖЕТ капитал фонд” ХЗХ-нд
хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “ЖЕТ капитал фонд” ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “ЖЕТ капитал фонд” ХЗХ /Б.Цогоо/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах болон олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН